

ЖАРГАЛАНТЫН НУРУУ ОРЧМЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ҮҮССЭН НӨХЦӨЛ

Н.БАЙГАЛМАА

Монгол Улсын Их Сургууль

Оршил

Жаргалантын нурууны алтны шороон орд нь Баянхонгор аймгийн төвөөс 60 км зайд оршино. Уг шороон ордын үүссэн хөгжлийг неогений өмнөх, неогений ба дөрөвдөгчийн гэсэн үндсэн гурван үе шатанд хуваан үзэж байна.

Неогенээс өмнөх эхний үе шатанд энэ районд гадаргын тэгширлийн явц явагдаж байсан ба газрын гадарга аажмаар тэгшрэлд орж, ялангуяа физикийн өгөршилд их өртөж байжээ. Үүнээс, дунд кембри-түрүү ордовикийн хлорит-серицит-кварцлаг занарууд өгөршилд ихээр автсан байна.

Хамгийн их идэвхтэй өгөршил нь ан цавшил ихтэй бүсийн дагуу, гидротермаль өөрчлөлтийн (карбонатитжих, цахиржилт, пиритжилт, беритизжих ба төмөржилт) үндсэн хэсэгт зонхилон явагдсан байна. Энд чулуулгууд боровтор улаан өнгөтэй элсэрхэг шаварлаг биетэд бараг бүрэн хувирсан байдаг.

Кварцат ба кварц-карбонатат судлууд, ялангуяа брекчлэгдсэн ба пиритчлэгдсэн (өөрчлөлт хувирлууд) биетүүд нь сайрга, жижиг үйрмэг болтлоо бутарч эвдэрснээс алтны үндсэн хэсэг чөлөөлөгдсөн болох нь тодорхой байдаг.

Тектоникийн харьцангуй тайван ба рельефийн сул хэрчигдлийн нөхцөлд элювийн хурдас удаан хугацаанд байрандаа хуримтлагдан үлдэж, тэр нь бараг бүрэн элсэнцэр, хайрганцар биетийг үүсгэжээ.

Дээрх үйл явц нь районы тэгширлийн үед хөвсгөр хурдасны алт нь үндсэн эх үүсвэрээс чөлөөлөгдөөд зогсоогүй, түүний элювиаль давхаргад тодорхой хэмжээний баяжилт явагдсаныг гэрчилж байгаа юм.

Элювиаль хурдсын цэнхэрдүү шаварлаг-сайргархаг-үйрмэг материалд (Баруун мухар-эрэгийн усан хагалбар) алт тэмдэгт төдийгөөс 80 г/м^3 хүртэл хэмжээгээр агуулагддаг.

Жаргалантын дүүргийн шороон ордууд нь гадаргын өгөршлийн эртний үлдэцтэй тодорхой орон зайн хувьд холбоотой үүссэн ба кайнозой хүртэл насны хурдсанд алт бараг байхгүй болохыг судалгааны үр дүн харуулж байна.

Хоёрдугаар үе шат нь неогены үед эртний гадаргын тэгширлийг идэгдэлд оруулах замаар доод дөрөвдөгчийг хүртэл хөгжсөн усан сүлжээнүүд анх үүсч

тогтжээ. Энэ хөндийнүүд бол гүнзгий ховил, бага биш өргөгдлийн улмаас 100-150 м-ээс хэтрэхгүй ер нь идэгдэлд их орсон бөгөөд аллювиаль-делювиаль хурдас ба ул чулуулгийн өгөршлийн бүс юм.

Энэ үе шатны үр дүнд Өлзийт гол, Байдраг голын хөндийнүүд, улмаар алтжилтын эртний гол Сайрын худаг (эртний үлдэц аллювиаль хурдас дахь шижирмэг) үүссэн байна. (Б.Батром, Т.Ноов, Э.Жамбаа и др. 1983).

Гурав дахь үе шатанд Жаргалантын нурууны элэгдэл идэгдлийн, өргөгдлийн үе болон орчин цагийн рельефийн тогтцууд хамаарна. Энэ цаг үе эртний аллювийн хурдас усны идэгдлийн процесс, тэгшрэлийн гадарга алгуур хэрчигдэлд автаж байсантай холбоотойгоор намхан дэнж, хуурай салаануудад болон аллюв-пролюви, пролювийн хурдаст алтны шижирмэг ордууд үүссэн байна.

Мухар-Эрэг, Өвөрчулуут болон бусад ордууд нь Жаргалантын нурууны баруун урд хажуугийн энгэр бэлд ул чулуулгийн (үндсэн эх үүсвэрүүд) дээд талын өгөршлийн бүтээгдэхүүний хэсгүүдээс, эртний аллюви хурдас усан идэгдэлд орсны үр дүнд үүсчээ.

Жаргалантын нурууны баруун-урьд хажуугийн гүнзгий бус гуу, налуу дагуу зүсэлт, занаржилттай холбоотой хөндлөн чиглэлийн жалга хөндийнүүдэд орд үүсэх тааламжтай нөхцөлд бий болжээ.

Доод палеозойн чулуулгаас тогтсон ул чулуулагт доод цэрдийн шаварлаг-алевритлэг хурдас сэлгэн нийлсэн нь Мухар-Эрэг ба Өвөрчулуутын хөндийнүүдийн дунд ба доод хэсгүүд нь алтны бөөгнөрөл үүсэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Ашигласан ном, зохиол

1. Аиздердзис Д.Я., Хаймакова В.Н., Хаймакова В.Д., Мартин В.И., Зеленко А.С. 1995. Геологические строение и полезные ископаемые дүүрэг хребта Жаргаланту-нуру в Баянхонгорском аймаке МНР. Уланбатор.
2. Б.Батром, Т.Ноов, Э.Жамбаа и др. 1983. Отчет о результатах детально разведочных работ, проведенных на месторождениях Мухар-Эрэг, Өвөрчулуут, Сайрын худаг за период 1978-1979, 1981-1982 г с подсчётом запасов россыпного золота.
3. Ш.Очирбат, Б.Батром, Ч.Батбаяр. 1989. Отчет о детальной разведке проведенной в Баянхонгорской рудной зоне в 1986-1988 г россыпных месторождениях золота Далт, Хоолой худаг, Баян-Ам, Алтан-Ам, Жаргалант.
4. Я.Болд, Б.Бат. 1999. Улаанбаатар. Шороон ордын геологийн үндэс.